

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны
үйл ажиллагааны мэдээлэл**

“Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр” арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж, энэхүү арга хэмжээний хүрээнд Дурсгалын хөшөөнд цэцэг өргөх ёслол үйлдэж, хэлмэгдэгсдийн ар гэрийнхэнд хүндэтгэл үзүүлж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Улс төрийн хэлмэгдүүлэлт” эсээ бичлэгийн уралдаан зохион байгуулсан.

Мөн цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос “Төгс баясгалант буян дэлгэрүүлэх хийд, Өлзийбадруулагч хийдийн лам нараар хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд, ар гэрийнхэнтэй хамтран Ганжуур, Данжуур, ерөөлийн ном хуруулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж 7 дугаар сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар цаг үеийн ажил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж удирдах ажилтнуудад үүрэг даалгавар болон цаашид анхаарах ажлын чиглэлийг өглөө.

Мөн өдөр аймгийн удирдлагууд 19 сумдын Засаг дарга нартай хурал хийж цаг үеийн асуудлаар үүрэг даалгавар өгч, өвөлжилтийн бэлтгэл, отор нүүдлийн асуудал, мал мах эдийн засгийн эргэлтэд оруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэх, цахим шилжилт зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч санал солилцсон.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Архангай аймгийн Засаг даргын тамгын газарт “Төрийн албаны шинэтгэл, үнэт зүйлс ба төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Сургалтад аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймаг, сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг зэрэг 66 байгууллагын дарга, ажилтны төлөөлөл 150 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.

Мөн Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэг даалгаврын хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын тамгын газар, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг зэрэг 40 байгууллага дээрхи сургалтыг өөрсдийн байгууллага дээрээ албан хаагчдадаа зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 982 албан хаагчийг хамруулж шинэ мэдлэг, мэдээллийг хуваалцах, цааш нь түгээх ажлыг зохион байгуулсан.

2023 онд Суварга хайрхан уулын төрийн тахилга болохтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол Улсын их сургууль, Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Музей, Цэнхэр сумын Засаг даргын тамгын газар хамтран 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газарт “Төрийн тахилгат Суварга хайрхан ууланд холбогдох түүх, шашин, соёлын судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний бага хуралд ШУ-ны доктор, профессор Л.Дашням, доктор Д.Мөнх-Очир, доктор, гавж Ц.Отгонбаяр, доктор О.Бумдарь, доктор С.Баянмөнх, докторант Д.Юмчинхорлоо, С.Дэмбэрэл, магистр Д.Галхүү нарын илтгэгчид урилгаар оролцож илтгэл тавьсан.

2022 онд Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой тохиож буйтай холбогдуулан БНАЛАУ-ын парламентын гишүүд, төлөөлөгчид Архангай аймагт 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр албан айлчлал хийлээ.

Архангай аймаг БНАЛАУ-ын Чампасак мужтай 2010 оноос найрамдалт харилцаа тогтоож, байгаль орчин, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд олон талт хамтын ажиллагаа өрнүүлж байгаа бөгөөд айлчлалын үеэр аймгийн удирдлагууд БНАЛАУ-ын төлөөлөгчдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлж аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл, боловсрол, нийгэм, хүмүүнлэгийн чиглэлд тодорхой ажлуудыг хэрэгжүүлэх талаар санал солилцсон.

“Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтийн болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” Ерөнхий сайдын 2022 оны 09 дүгээр албан даалгавар, “Өвөлжилийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр албан даалгаврыг сум, байгууллагын удирдлагуудад хүргүүлж, хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах ажлын хэсгүүд сум, байгууллагуудад ажиллаж хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2022 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг Архангай аймагт 2022 оны 09 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд явуулахаар төлөвлөсөн бөгөөд цэрэг татлагын ажил хугацаандаа явагдаж байна.

“Архангай түншлэл-2022” үзэсгэлэн худалдаа 2022 оны 09 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулагдаж байна.

Цахим шилжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Ай Си Ти групп” ХХК шалгарч, гүйцэтгэгчтэй 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

“Цахим Архангай” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, 19 сумын Эрүүл мэндийн төв, 33 ерөнхий боловсролын сургууль, 19 сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 агентлагт удирдлага, зохион байгуулалталтын цахим шийдэл, аймгийн нэгдсэн болон 19 сумын цахим хуудсыг шинэчлэх, хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, аймгийн орон зайн мэдээллийн систем, автомат шалган нэвтрүүлэх цахим шийдэл, аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 05-наас 07-ны өдрүүдэд гүйцэтгэгч компанийн төлөөлөл Архангай аймагт ажиллаж ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулж 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор дээрхи системүүдийг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

ХУР, ДАН системээр иргэдэд нийт 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд 2022 оны 05 дугаар сард Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ шинээр "e-mongolia" системд нэмсэнээр орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан нийт 211 үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хүрээнд Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсарч суурилуулах, Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга барих ажлууд хийгдэж дууссан.

Мөн хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Өндөр-Улаан сумын Азарга баг, Ихтамир сумын Бугат, Хөхнуур баг, Тариат сумын Алтаад багуудад холбогдох дэд бүтцийн ажлууд хийгдэж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 1,987,207.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,909,821.5 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 96.1 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,614,966.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,685,906.9 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 104.4 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 9,956,880.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 10,557,267.9 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 106.0 хувь байна.

Тендер, худалдан авалтын ажиллагаа

2022 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 123706.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 116751.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн. Төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ хасагдсан.

2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 623.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3-4 удаа зарласан боловч оролцогч байхгүй байна. Тендерийг дахин зарласан. Үлдэх 122383.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 82 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгож гэрээг байгуулсан.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 81,527,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,704,9 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх их засвараар 1,100,0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсанаас оны эхний 9 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгөөр 10,644,1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,219,4 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засвараар 905,6 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

Аймгийн хэмжээнд 2022 оны 9 дүгээр сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 4 удаа гарсанаас: Объектын гал түймэр 1, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин 2, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарсан байна.

Дээрх гамшиг ослын дуудлаганд онцгой байдлын газрын алба хаагч болон мэргэжлийн ангийн 35 алба хаагч, 7 техник хэрэгсэлтэй ажиллаж 17 иргэний амь нас, 85 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Гэмт хэрэг, зөрчил

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт 2040 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 775, зөрчлийн шинжтэй 1265 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 488 буюу 23.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд 303 холбогдогчтой 1.3 тэр бум төгрөгийн хохиролтой 403 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 123 буюу 30.5 хувь, холбогдогч нь 75 буюу 24.7 хувиар өссөн байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 115 буюу 28.5 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 139 буюу 34.4 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 40 буюу 10.3 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 23 буюу 5.7 хувь нь авто ослын гэмт хэрэг, 21 буюу 9.1 хувийг залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 9 дүгээр сард шүүх эмнэлгийн шинжилгээ 38, криминалистикийн шинжилгээ 7, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 126, тусгай шинжилгээ 16-г хийсэн байна.

2022 оны 9 дүгээр сард Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 3057481.6 төгрөгийн мөнгөн дүн бүхий 508 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 47.4, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 27.4 байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Иргэний бүртгэл

Төрсний бүртгэл – 112

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 5

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 3

Гэрлэсний бүртгэл - 14

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 2

Үрчилсний бүртгэл - 2

Нас барсны бүртгэл – 43

Шинээр иргэний үнэмлэх олгосон – 122

Дахин олгосон – 37

Солиулсан - 166

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 12

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 9

Худалдах худалдан авах гэрээ – 60

Бэлэглэлийн гэрээ – 7

Барьцааны эрхийн бүртгэл – 150

Өв залгамжлал – 9

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 2

Лавлагаа – 9

Бусад эрхийн бүртгэл – 6

Хууль хяналтын байгууллагад нийт 27 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 2618070 төгрөг, тэмдэгтийн хураамжид 31500 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 12603200 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл

Шинээр бүртгүүлсэн – 13

Өөрчлөлт – 17

Тамганы хяналтын дугаар олгосон – 15

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 19600, хүүхдийн цэцэрлэгт 6700, нийт 26300 суралцагч боловсрол эзэмшиж байна.

Энэ хичээлийн жилд Архангай аймагт 2047 хүүхэд 1-р ангид элсэн орсон. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн зорилгыг “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” хэмээн тодорхойллоо.

2022 онд боловсролын салбарт улсын болон орон нутгийн төсвийн 41.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 26 барилга, өргөтгөл, их засварын ажил, үүнд багшийн хөгжил, судалгааны арга зүйн төв-1, сургууль-8, дотуур байр-1, цэцэрлэг-7 нийт 17 барилгыг улсын төсвийн 40,4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр шинээр барих, сургууль- 3, спорт заал-4, цэцэрлэг-1 нийт 8 барилгад улсын төсвийн 200,0 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 902,0 сая, нийт 1,1 тэрбум төгрөгийн их засварын ажлыг тус тус гүйцэтгэж байгаагаас 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар барилга, засварын ажлын гүйцэтгэл дунджаар 65.7 хувьтай байна.

Соёл, урлаг

Соёл, урлагийн ажилтны баярын өдрийг тохиолдуулан 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн Соёл, урлагийн газар, аймгийн Музей, Номын сан, Хөгжимт драмын театр зэрэг соёл урлагийн байгууллагууд хамтран “Цэцэрлэг хот соёлын орон зай” өдөрлөгийг Эрдэнэбулган сумын Заяын цогцолборт зохион байгууллаа.

Өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд Соёл, урлагийн газар ерөнхий боловсролын сурагчдын дунд цардмал замын болон гар зургийн уралдаан, аймгийн Нийтийн номын сан үндэсний хэл, бичгээр “Хамтдаа уншья”, “Хамтдаа бичье” уралдаан, уран бичлэгийн үзэсгэлэн, монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн гаргаж, Хөгжимт драмын театрын уран бүтээлчид шинэ уран бүтээлийн тоглолтоо толилуулж, “Хамтдаа дууля, бүжиглэе, уншья” уралдааныг тус тус зохион байгуулж иргэд хүүхдэд багачуудад нэг өдрийн турш соёл урлагийн үйлчилгээг үзүүлсэн.

Мөн аймгийн Соёл, урлагийн газар, Музей, Нийтийн номын сан, Хөгжимт драмын театрын ажилтнууд хамтран “Хандлагаа өөрчилье Хамтдаа бүтээе” уриан дор Заяын цогцолбор орчмын газрын их цэвэрлэгээг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн дагуу “Номын баярын өдөр”-ийг аймгийн Нийтийн номын сан аймгийн Соёл урлагийн газар, Эрдэнэбулган сумын Лаборатори 1 дүгээр сургуультай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 16-наас 18-ны өдрүүдэд “Үндэсний бичиг, үсэг, номын өдрүүд-2022” нэрийн дор зохион байгуулж, 10 гаруй сум, сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгжүүд оролцон үйл ажиллагаагаа сурталчилсан бөгөөд 2000 гаруй үзэгч, сонирхогч оролцлоо.

Аймгийн Хөгжимт драмын театр Улсын хүүхэлдэйн театрын уран бүтээл болох В.Гауфын зохиол “Том хамарт одой” хүүхдийн жүжгийг тайзнаа шинээр тавьж 2022 оны 09 дүгээр сарын 10-аас эхлэн Эрдэнэбулган, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат сумдын ЕБС-ын сурагчдад хүргэсэн байна. Тус жүжгийг нийт 1200 гаруй хүүхэд үзсэн байна.

Эрүүл мэнд

2022 оны 5 дугаар сарын 01-нээс улсын хэмжээнд эхэлсэн хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд Архангай аймагт 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 0-5 насны 2083, 6-17 насны 3498, 18-30 насны 790, 31-45 насны 675, 46-60 насны 436, 61-ээс дээш насны 88, нийт 7570 иргэн үзлэгт хамрагдсанаас эрүүл илэрсэн 3388, эрсдэлтэй илэрсэн 392, өвчтэй илэрсэн 3790 иргэн байна.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төв 2022 онд Архангай аймгийн Ихтамир сумын Хөхнуурт 500 гаруй сорьц дээжийг шинжилснээс махчин шувуунаас нян, урт сүүлт зурам, монгол огдойноос тарваган тахлын эсрэг биеийг илрүүлсэн. Судалгаа шинжилгээний зэрэгцээ “Тарваган тахлын халдвараас сэргийлэх хяналт” сургалт сурталчилгааг 14 сумын Эрүүл мэндийн төвийн ажилтнууд, онцгой комисс, шуурхай штабын гишүүд, мэргэжлийн хүмүүст хийсэн. Төв суурин газарт тарвага оруулахаас сэргийлэх хяналтын пост, ажиллуулж байгаа бөгөөд 2022 оны 9 дүгээр сард Завхан, Говь-Алтай, Архангай аймгийн нутаг дэвсгэрт агнасан тарвагыг аймгийн нутаг дэвсгэрээр тээвэрлэсэн 15 холбогдогчтой зөрчлийг илрүүлж 98 тарвагыг халдвар хамгааллын дэглэмийн дагуу устгаж хариу арга хэмжээ авсан байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

/2022.09.28-ны өдрийн байдлаар/

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/- 17929

Үүнээс: 2022 онд – 5066

Сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол – 26 (9 сарын 21-28)

Нас баралт:

Нийт нас баралт – 42

Үүнээс: 2021 онд – 39

2022 онд - 3

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/ - 53186

Үүнээс 2022 онд: - 10029

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 164

Үүнээс эерэг – 25

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ /2021-2022 он/ - 89454

Үүнээс 2022 онд - 11942

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 20

Үүнээс эерэг – 1

Вакцинжуулалт:

1-р тунд 60853 хүн буюу 86.23 % /12-оос дээш нас/

2-р тунд 57587 хүн буюу

81.60% /12-оос дээш нас/

3-р тунд 27327 хүн буюу 44.79 % /18-аас дээш нас/

4-р тунд 2515 хүн буюу 4,12% /18-аас дээш нас/

Биеийн тамир, спорт

Олон улсын цээж тоолол, соробан сампингийн уралдаанд амжилттай оролцож 80 орны 8000 гаруй хүүхэдтэй оюун ухаан, мэдлэг чадвараараа өрсөлдөж "Мөнгөн цом"-ын эзэд болсон Б.Маргад-Эрдэнэ, Ө.Энэрэл, Узбекистан улсын Ташкент хотноо зохион байгуулагдсан Ази тивийн аварга шалгаруулах 100 буудалт, 64 буудалт, Турк даамны төрөлд амжилттай оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн П.Сурмаасүрэн, Э.Эрхэмбаяр, Г.Хүслэнзаяа, Б.Нарансолонго, А.Пүрэв-Очир, Б.Ганхүү нарт нарыг журмын дагуу аймгийн Засаг дарга хүлээн авч шагнаж урамшууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 9 дүгээр сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 913 иргэн бүртгэлтэй байгаагаас 405 эмэгтэй. Шинэ ажлын байр 488 үүнээс байнгын ажлын байр 293, улирлын ажлын байр 14, түр ажлын байр 181 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2022-2023 онд 19 сумын 101 багийн 8207 хот айлд 19.4 мянган малчин болон мал бүхий өрхийн 6.1 сая толгой малыг өвөлжүүлж, хаваржуулахаар төлөвлөж байна.

2021 онд 2.4 сая толгой хээлтэгч мал тоологдож, төллөвөл зохих 2.1 сая толгой хээлтэгч малын 95.1 хувь буюу 2.0 сая толгой эх мал төллөн, 1.9 сая толгой төл хүлээн авч төл бойжилт 96.7 хувьтай бөгөөд аймгийн хэмжээнд 1.4 сая толгой малыг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөсөн.

Малчид 80.0 мянган тн өвс, 1300 тн гар тэжээл бэлтгэхээс 51.7 мянган тн байгалийн хадлан, 10 тн үйлдвэрийн тэжээл, 613 тн гар тэжээл бэлтгэсэн нь 64.0 хувьтай байна. Зуншлага сайн байсан ч хадлангийн унац тааруу байна.

Аймгийн аюулгүйн нөөцөд 1670 тн өвс, 620 тн тэжээл бэлтгэхээс одоогийн байдлаар 615.5 тн өвс, 259.9 тн тэжээл төвлөрүүлсэн нь 62.9 хувьтай байна.

2022 оны 09 дүгээр сарын 15-наас эхлэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж, 09 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 52.6 хувь буюу 491036 үхрийг хамруулж, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний чиглэлээр холбогдох хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

Газар тариалан

Аймгийн хэмжээнд 2022 онд 8265 га-д үр тариа, үүнээс 7965 га-д улаанбуудай, 4100 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, 275 га-д төмс, 166 га-д хүнсний ногоо, 80 га-д жимс жимсгэнэ, нийтдээ 13486 га-д тариалалт, 7600 га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөснөөс 10863 га-д үр тариа үүнээс 10453 га-д улаанбуудай, 70 га-д арвай, 340 га-д хошуу будаа, 1225 га-д тосны ургамал, 2440 га-д малын тэжээл, 126 га-д хүнсний ногоо, 263 га-д төмс, 84 га-д жимс, жимсгэнэ, нийт 15001 га талбайд тариалалт хийсэн. Төлөвлөсөн хэмжээнээс 11 хувиар нэмэгдсэн.

Ургац хураалтын ажил эхэлсэн, урьдчилсан балансаар га-гаас 12 цн буюу 12544 тн улаанбуудай, 492 тн хошуу будаа, га-гаас 21 цн буюу 5125 тн малын тэжээл, 613 тн тосны ургамал, га-гаас 90 цн буюу 2368.8 тн төмс, 1010.4 тн хүнсний ногоо, нийт 22153.2 тн ургац хураан авахаар тооцсон.

Ургац хураалтад комбайн, хадагч - 18, будаа цэвэрлэгч – 6, үр сортлогч – 1, ачигч – 7, төмс ухагч – 20 зэрэг чиргүүл дүүжин машин ажиллаж байна.

Цаг агаарын байдал таагүй, шөнөдөө хүйтэн хоносноос үр тарианы болц удааширсан. Одоогийн байдлаар үр тариа 270 га-д ангилан, төмс 120 га-гаас 960 тн, хүнсний ногоо 126 га-гаас 1010,4 тн, тэжээлийн ургамал 450 га-гаас 945 тн-ыг тус тус хураасан. Орон нутгийн 148 хүнийг түр ажлын байраар хангасан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Архангай аймгийн Өгийнуур суманд “Ногоон Ази-Эко сүлжээ” төрийн бус байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж байгаа цөлжилтийг бууруулах төслийн хүрээнд байгуулагдсан “Өгий эко шим” нөхөрлөл нь 2019 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж, ил талбай болон хүлэмжинд хайлаас, улиас, голтбор, агч зэрэг 5 төрлийн модны үржүүлэг хийж жилд дундажаар 60 орчим мянган суулгацыг бэлтгэн нийлүүлж, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалж органик хүнснийг иргэдэд нийлүүлэн, 25 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна

Тус нөхөрлөл нь төслийн хугацаанд 40 мянган чацаргана, үхрийн нүдний суулгацыг тарьсан бөгөөд энэ жилээс жимсээ хурааж эхлээд байна.

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 19 сумын хэмжээнд 317716 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Энэ жилийн мод тарих ажлын хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэн сайжруулж мод тарих чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч хамтран ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байна. Мөн ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу ойн мэргэжлийн

байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 468.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс ажлын гүйцэтгэл 67.8 хувьтай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол Улсын их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтын хээрийн дадлага сургуулилт 09 дүгээр сарын 22-ны өдөр Архангай аймагт эхэл байгаа бөгөөд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүс нутгийн онцлогт тохирсон модны зүйлийг сонгох, үр түүж бэлтгэх, тарьц суулгац ургуулах, мод тарьж ургуулах, арчлан хамгаалах технологийн талаар нэгдсэн мэдлэг эзэмшин иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зааж сургах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах “Сургагч багш”-ийг бэлтгэ энэхүү сургалтад 19 сумын 57 иргэн хамрагдлаа.

Улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг Ихтамир, Булган сумын доройтсон ойн санг нөхөн сэргээх ажлыг 50 га, Хайрхан суманд 10 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг 10 га талбайд гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. Дээрх 2 ажлын хүрээнд нийт 133 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөж байна.

Улсын төсвийн 198.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мастер Эрчим” ХХК нь 2022 оны 10 дугаар сард ногоон байгууламж байгуулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Хог хаягдлын менежмент

Тэрхийн цагаан нуурын хойд, урд хэсэг Чулуутын хавцал, Хөх нуур, хойд Тамир голын эх, Суварга хайрхан Ширдэгийн гол, Ихтамир сумын Хойд тамирын гол, Өндөр-Улаан сумын Бэлхи багт орших Чулуутын гол, Тарвуу, Тамирын голын голдирол дагуух хог хаягдал болон нийтийн эзэмшлийн зам талбай, голын голдирол, улсын болон орон нутгийн чанартай зам дагуух хог хаягдал цэвэрлэх ажлыг 354 аж ахуй нэгж байгууллагын 8503 ажилтан албан хаагч, иргэд оролцож, 361 машин техник ашиглан 1832.8 га талбай, 122 км голын голдирол, 548 км улсын болон орон нутгийн чанартай зам цэвэрлэн 1520.3 тн хог хаягдал, малын сэг сэм ачиж зайлуулж төвлөрсөн хогийн цэгт хаяаад байна. Хог цэвэрлэгээний ажил үргэлжиж байна.

Чулуут сумын хогийн цэгийг гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг “Газрын гагнаас” ХХК гүйцэтгэж ажил хүлээж авах комисс 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр ажиллаж үүрэг даалгавар өгөөд байна, Хангай сумын хогийн цэгийн хэмжээг бууруулах, хог хаягдлыг түрж дарж булшлах ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна, Хотонт, Хангай сумд хогийн цэгийг камержуулсан.

“Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь” төслийн 45 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 45 сая, нийт 90 сая төгрөгний санхүүжилтээр Хайрхан суманд “Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын санал санаачилгыг дэмжих нь төсөл” хэрэгжиж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Энэхүү төслийн хүрээнд ангилдаг хогийн сав 6 ширхэг, хоёрдогч түүхий эд авах автомат машин 1 ширхэг, албан байгууллагын ангилдаг хогийн сав 6 ширхэг, хог шахагч машин 1 ширхэг, хог шатаах зуух 1 ширхэг, 10 айлын хашааны тохижилт жорлон, хогийн савыг шийдвэрлэж хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.

Хоршоо, жижиг дунд үйлдвэр

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/168 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 08:30 цагаас 07 дугаар сарын 07-ны өдрийн 08:30 цаг хүртэл орон даяар нэгэн зэрэг цахимаар хүлээн авсан бөгөөд нийт 10 төсөл бүртгүүлснээс 3 төсөл хүчингүй болж хасагдсан 7 төсөл шалгарсан.

2022 оны Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд Жаргалант, Тариат, Чулуут, Булган, Төвшрүүлэх сумын 21 хоршоо, аж ахуйн нэгжийн төсөлд 555.0 сая төгрөгийн зээлийг олгож 44 ажлын байр бий болсон.

Хүнсний хангамж

Аймгийн хэмжээнд хүнсний чиглэлийн 74 үйлдвэр, цех 239 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Дотоодын үйлдвэрлэлээр аймгийн хүн амын хүнсний хэрэгцээний 40.9 мянган тн мах бэлтгэж 100%, 35.3 сая литр сүү бэлтгэж 100%, 0.32 мянган тн гурил бэлтгэж 12.5%, 2.58 мянган тн гурилан бүтээгдэхүүн бэлтгэж 42%, 2.2 мянган тн төмс бэлтгэж 57%, 1.3 мянган тн хүнсний ногоо бэлтгэж 23%, 0.025 мянган тн жимс, жимсгэнэ бэлтгэж 0.5%, 0.05 мянган тн өндөг бэлтгэж 10 хувийг тус тус хангаж байна.

Аймгийн хэмжээнд Эрдэнэбулган, Ихтамир, Хангай, Батцэнгэл, Тариат, Хотонт, Эрдэнэмандал, Цэнхэр, Өлзийт сумдад мах хадгалах 1560 тн багтаамжтай 23 агуулах, Өлзийт, Цэнхэр, Хотонт, Жаргалант, Эрдэнэмандал, Ихтамир, Өгийнуур, Төвшрүүлэх, Батцэнгэл, Өгийнуур сумдад төмс, хүнсний ногоо хадгалах 1700 тн багтаамжтай 36 зоорь байна.

Энэ онд Эрдэнэбулган суманд Зах зээл бэлчээрийн удирдлага нэмэлт санхүүжилт төслөөс төмс, хүнсний ногооны механикжсан 50 тн багтаамжтай 1 зоорь, Булган сум ОНХС-аас 40 тн хөргүүртэй агуулахыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

19 сумын хүнсний хангамж, нөөцийн мэдээг хүнсний нөөцийн цахим системд мэдээлж байгаа бөгөөд сүүлийн 7 хоногийн судалгаагаар малын мах 136.8 тн буюу 9 хоног, гурил 263 тн буюу 34 хоног, гоймон 27.3 тн буюу 2 хоног, будаа 88.95 тн буюу 23 хоног, сахар 69.8 тн буюу 28 хоног, ургамлын тос 30.01 тн буюу 17 хоног, давс 27.9 тн буюу 70 хоног, ундны ус 48.3 мянган литр буюу 1 хоног, хуурай сүү 9.06 тн буюу 6 хоног, төмс 49 тн буюу 5 хоног, хүнсний ногоо 24.7 тн буюу 1 хоног, өндөг 1.65 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Барилга байгууламж, дэд бүтэц, орон сууц,

Архангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын тендер зарлагдаж гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч, 650.0 сая төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажлаа эхэлсэн байна.

Архангай аймгийн Хангай сум 2022 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 15,0 сая төгрөгийн санхүүжилтээр, сумын төвийн гудамж болон хашааны хаягжуулалтыг стандартын дагуу шинэчилж, цахим хаягжуулалттай болсон.

Хангай сум нь гудамж, хашааны цахим хаягжуулалт хийсэн анхны сум болсон бөгөөд цахим хаягжуулалтыг орчин үеийн цахим технологи болох openstreetmap.org зургийн платформ дээр суурилан хийж, олон нийтэд нээлттэй байдлаар бүтээснээр олон нийтэд нээлттэй, үнэгүй [organic maps](https://www.organicmaps.com), [maps.me](https://www.maps.me), [magic.maps](https://www.magic.maps.com) гэх мэт аппликэйшнүүдийг ашиглан цахим хаягжуулалтыг өдөр тутмынхаа хэрэглээнд ашиглах боломжтойгоос гадна хашааны хаягийг олох хайлт хийх, мөн хүрч очих дөт зам, чиглэлийг заадгаараа онцлог давуу талтай юм.

Архангай аймгийн төв Эрдэнэбулган сумын доторх хатуу хучилттай 2100 м² авто замын засвар, арчлалтын ажлыг “ЛМДШ” ХХК орон нутгийн авто замын сангийн 239,0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн.

“Тамир таун” ХХК гүйцэтгэсэн 12 айл, “Идэрживаа” ХХК гүйцэтгэсэн 60 айл, нийт 72 айлын 2 орон сууц 2022 оны 9 дүгээр сард ашиглалтад орсон.

2022 онд аймгийн хэмжээнд дараах орон сууц баригдаж байна. Үүнд:

д/д	Захиалагч иргэн, аж ахуйн нэгж	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Давхрын тоо	Айлын тоо	Барилгын ажлын гүйцэтгэл
1	Иргэн Сүхээ	“Тамир таун” ХХК	4	12	100%
2	Иргэн Б.Үүрцайх	“Цагаан Сүмбэр” ХХК	5	50	90%

3	Иргэн Ж.Нэргүй	“Гурван Тамир” ХХК	5	15	30%
4	Иргэн Б.Бадрал	“Гэрэгэ” ХХК	5	17	85%
5	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	5	15	85%
6	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	6	60	100%
7	Иргэн Н.Номин	“Тайгер дизайн” ХХК	4	12	30%
8	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	6	42	95%
9	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	7	49	50%
10	Иргэн Д.Батбаяр	“Класик булдинг” ХХК	9	128	0%
11	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	9	54	50%
12	Иргэн Нямдорж		9	-	40%
13	Иргэн Д.Чулуунбаатар	“Эсгэл” ХХК	5	18	80%
14	Иргэн Б.Шинэбаатар		5	15	20%
15	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	5	40	60%
16	Иргэн Бямбаа	“Өлзий тээл” ХХК	5	40	60%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----